



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 23 өдөр

Дугаар 108

Мандалговь

Үндсэн хөрөнгө бүртгэх, балансаас
балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4 дүгээр бүлгийн 4.2 дахь заалт, 5 дугаар бүлгийн 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

Нэг: Аймгийн Эрүүл мэндийн газарт шаардлагатай нийт 9,367,944 /есөн сая гурван зуун жаран долоон мянга есөн зуун дөчин дөрөв/ төгрөгийн үндсэн хөрөнгийг хавсралтын дагуу бэлтгэж бүртгэлд тусгах, 1,736,379 /нэг сая долоон зуун гучин зургаан мянга гурван зуун далан ес/ төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй Делл маркын компьютерийг Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвд балансаас балансад шилжүүлэхийг тус тус зөвшөөрсүгэй.

Хоёр: Аймгийн Эрүүл мэндийн газрын дарга /Г.Бат-Орших/, Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн дарга /Э.Саруулжаргал/ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;


2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

Гурав: Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн Засаг дарга (О.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ДАРГА

С.СҮХБААТАР





Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2019 оны 12 дугаар сарын
23 өдрийн 108 тогтоолын нэгдүгээр хавсралт

Эрүүл мэндийн газрын шинээр
бэлтгэсэн хөрөнгийн мэдээлэл

№	Хөрөнгийн нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас хандивласан					
1	Дугуй ширээ	ш	1	1,153,872	1,153,872
2	Сэтгүүлийн ширээ	ш	1	371,269	371,269
3	Шилэн ширээ	ш	1	2,385,203	2,385,203
Төсвийн хөрөнгөөр					
4	Олон үйлдэлт принтер	ш	1	403,900	403,900
5	Олон үйлдэлт принтер	ш	1	527,900	527,900
6	Олон үйлдэлт принтер	ш	1	959,900	959,900
7	Зөөврийн компьютер	ш	1	1,795,900	1,795,900
8	Угаалгын машин	ш	1	320,000	320,000
9	Төмөр сейф	ш	1	350,000	350,000
10	Дугуйтай сандал	ш	10	110,000	1,100,000
	Нийт дүн				9,367,944 /есөн сая гурван зуун жаран долоон мянга есөн зуун дөчин дөрөв/